



**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО**
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД

erxes
MONGOLIA LLC

ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ

(Аялал жуулчлал – Технологийн стратегийн түншлэл)

2026 оны 03 дугаар сарын 11-ний өдөр

№/ 002

Улаанбаатар хот

НЭГ. ТАЛУУД

Нэг талаас: Улаанбаатар хот, СБД, 1 дүгээр хороо, Олимпийн гудамж 12/1, Очир центр, 505 тоот хаягт байрлах “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” Нийтийн эрх зүйн хуулийн этгээд (РД: 8398801, цаашид “МТО” гэх), түүнийг төлөөлж Ерөнхийлөгч Т.Баттулга,

Нөгөө талаас: Улаанбаатар хотод байрлах “Эрксис Монголиа” ХХК (РД: 6329438, цаашид “Эрксис Монголиа” гэх), түүнийг төлөөлж Хамтран үүсгэн байгуулагч, захирал Б.Наран, цаашид хамтад нь “Талууд” гэх.

ХОЁР. САНАМЖ БИЧГИЙН ЗОРИЛГО

2.1. Талууд энэхүү санамж бичгийн хүрээнд дараах зорилгыг хэрэгжүүлэхийн төлөө хамтран ажиллана:

2.1.1. Монгол Улсын аялал жуулчлалын салбарын дижитал шилжилтийг дэмжих, технологид суурилсан менежмент, маркетинг, үйл ажиллагааны шийдлүүдийг нэвтрүүлэх;

2.1.2. Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны гишүүдэд зориулсан харилцагчийн удирдлагын удирдлагын систем (Customer Relationship Management - CRM)

2.1.3. Аялал жуулчлалын салбарын байгууллагуудын дижитал чадавхыг нэмэгдүүлэх, технологийн инновацийг нэвтрүүлэх;

2.1.4. “Go Mongolia – Always Moving” үндэсний брэндийн хүрээнд дижитал маркетинг болон технологийн шийдлүүдийг хамтран хөгжүүлэх;

2.1.5. Монгол Улсын аялал жуулчлалын салбарын дижитал экосистемийг хөгжүүлэх, салбарын мэдээллийн нэгдсэн орчныг бий болгох.

ГУРАВ. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

3.1. Аялал жуулчлалын салбарт дижитал технологи нэвтрүүлэх чиглэлд талууд дараах ажлыг хамтран хэрэгжүүлнэ:

3.1.1. Тур оператор компаниудад зориулсан аяллын менежментийн систем (Tour Management System – TMS) нэвтрүүлэх, хөгжүүлэх;

3.1.2. Зочид буудал, жуулчны баазуудад зориулсан зочлох үйлчилгээний удирдлагын систем (Property Management System – PMS) нэвтрүүлэх, хөгжүүлэх;

3.1.3. Аялал жуулчлалын үйлчилгээний борлуулалт, захиалга, хэрэглэгчийн туршлагыг сайжруулах дижитал платформ, системүүдийг хөгжүүлэх;

3.1.4. Тур оператор, зочид буудал, жуулчны бааз, тээвэр, аяллын үйлчилгээний байгууллагуудыг холбосон дижитал интеграц, технологийн экосистемийг хөгжүүлэх.

3.2. Аялал жуулчлалын салбарын байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих технологийн дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлд талууд дараах байдлаар хамтран ажиллана:

3.2.1. Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны үйл ажиллагааг дэмжих Back Office системийг хөгжүүлэх;

3.2.2. Холбооны гишүүн байгууллагуудын мэдээлэл, үйл ажиллагаа, харилцаа холбоог удирдах дижитал платформ бий болгох;

3.2.3. Салбарын сургалт, арга хэмжээ, гишүүнчлэл, харилцаа холбоог удирдах онлайн систем хөгжүүлэх.

3.3. Аялал жуулчлалын салбарын мэдээлэл, дата суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих чиглэлд талууд дараах байдлаар хамтран ажиллана:

3.3.1. Аялал жуулчлалын салбарын байгууллагуудаас бүрдэх мэдээллийн нэгдсэн дата орчныг бий болгох;

3.3.2. Аяллын урсгал, хэрэглэгчийн зан төлөв, зах зээлийн чиг хандлагыг тодорхойлох дата анализ, судалгаа хамтран хийх;

3.3.3. Аялал жуулчлалын салбарын статистик мэдээлэл, бизнесийн үзүүлэлтүүдийг харах аналитик болон дашбоард систем хөгжүүлэх;

3.3.4. Салбарын бодлого боловсруулах, стратеги төлөвлөлтийг дэмжих мэдээллийн сан болон дата шийдлийг хөгжүүлэх.

3.4. Талууд салбарын маркетинг, борлуулалтын дижитал шийдлийг хөгжүүлэх чиглэлд дараах байдлаар хамтран ажиллана:

3.4.1. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих дижитал маркетингийн хамтарсан кампанит ажил хэрэгжүүлэх;

3.4.2. Онлайн борлуулалтын сувгийг хөгжүүлэх, хэрэглэгчийн туршлагыг сайжруулах технологийн шийдэл нэвтрүүлэх;

3.4.3. Tourism Week болон бусад салбарын арга хэмжээнд технологийн шийдэл танилцуулах, хамтран оролцох.

ДӨРӨВ. АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 4.1. Талууд хамтын ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор хамтарсан ажлын хэсэг байгуулна.
- 4.2. Жил бүр хамтарсан үйл ажиллагааны төлөвлөгөө баталж хэрэгжилтийг дүгнэнэ.
- 4.3. Энэхүү Санамж бичиг нь талуудын стратегийн хамтын ажиллагааны хүрээг тодорхойлох бөгөөд шууд санхүүгийн үүрэг үүсгэхгүй.

ТАВ. ХУГАЦАА

5.1. Энэхүү Санамж бичиг нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж, талууд хамтын ажиллагааг үргэлжлүүлэх хүсэлтэй байгаа хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

5.2. Талуудын аль нэг нь энэхүү Санамж бичгийн хүрээнд хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон, эсхүл хамтын ажиллагааг цаашид үргэлжлүүлэх шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд нөгөө талдаа бичгээр мэдэгдснээс хойш 30 (гуч) хоногийн дараа Санамж бичгийг цуцалж болно.

5.3. Энэхүү Санамж бичгийг хэрэгжүүлэх явцад талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН:

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН
ХОЛБООНЫ ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ

Э.ТЭНГИСБОЛД



ЭРКСИС МОНГОЛИА ХХК-ИЙН
ХАМТРАН ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ,
ЗАХИРАЛ

Б.НАРАН

